2026оны Хусо Их Сургуулийн Солонгос хэлний сургалтын төвийн элсэлтийн заавар

호서대학교
한국어교육센터
HOSEO UNIVERSITY
KOREAN LANGUAGE CENTER

Гарчиг

01. Элсэлтийн дараалал ····· 2
02. Элсэлтийн хуваарь ····· 2
03. БҮрдҮҮлэхбичиг баримт ····· 3
04. Сургалтын төлбөрболон зардал ····· 3
05. Бусад зҮйлс ····· 4

호서대학교
HOSEO UNIVERSITY

БНСУ, ЧҮнчоннам-до, Асан хот, Бэбан-ып, Хосө-ру 79-р гудамж, 20 Кан Сог Гю боловсролын байр, 101 тоот (Шуудангийн индекс: 31499)

01 Элсэлтийн дараалал

Элсэгчдэд тавигдах шаардлага (Шалгуур)

■ Солонгос хэл эх хэл нь биш байх

■ БҮрэн дунд сургууль төгссөн (high school) эсвэл тҮҮнтэй дҮйцэхҮйц боловсролын зэрэгтэй байх

■ Хувь хҮний нөхцөл байдлаас шалтгаалж бҮртгҮҮлэх боломж өөр өөр байж болох тул холбоо барих хэлтсээс зөвлөгөө авна уу.

БҮртгэл	Элсэлтийн шалгалт	Шалгаруулалтын хариу	Сургалтын төлбөр төлөх	Виз авах ба Хилээр нэвтрэх
Шуудангаар бҮрт-гҮҮлэх (Эх хувь) or Имэйлээр бҮртгҮҮлэх (PDF)	Бичиг баримтын шҮҮлт & Ярилцлага	Хувь хҮнд нь мэдэгдэх & Төлбөрийн хуу-дас гаргах	Төлбөр баталгаажуулах & Элсэлтийн зөв-шөөрлийн бичиг	Виз (D-4) авах & Хилээр нэвтрэх

02 БҮртгэлийн хуваарь

Ангилал	1-р улирал / 20 долоо хоног (2026.03.05~08.05)		2-р улирал / 20 долоо хоног (2026.09.01~2027.02.02)	
	Хаврын улирал / 10 долоо хоно ('26.03.05~05.21)	Зуны улирал / 10 долоо хоног (05.26.~08.05)	Намрын улирал / 10 долоо хоног ('26.09.01~11.13)	Өвлийн улирал / 10 долоо хоног (11.23.~'27.02.02)
Элсэлтийн өргөдөл хҮлээн авах	• 2025.11.10.(Да) ~2026.01.09(Ба)	• 2026.02.02.(Да) ~04.10.(Ба)	• 2026.05.11.(Да) ~ 06.26.(Ба)	• 2026.08.03.(Да) ~ 10.09.(Ба)
Тэнцсэн элсэгчдийг зарлах	• 2025.12.08.(Да)) -аас тус тусад нь мэдэгдэнэ	• 2026.03.23.(Да)) -аас тус тусад нь мэдэгдэнэ	• 2026.06.08.(Да)) -аас тус тусад нь мэдэгдэнэ	• 2026.09.21.(Да)) -аас тус тусад нь мэдэгдэнэ
Сургалтын төлбөр төлөх	• 2025.12.10.(Лх) ~ 2026.01.16(Ба)	• 2026.03.25.(Лх) ~ 2026.04.10(Ба)	• 2026.06.10.(Лх) ~ 07.17(Ба)	• 2026.09.23.(Лх) ~2026.10.09(Ба)
Суралцах эрхийн бичиг олгох	• 2025.12.15.(Да) -аас дарааллаар олгоно	• 2026.03.30.(Да) -аас дарааллаар олгоно	• 2026.06.15.(Да) -аас дарааллаар олгоно	• 2026.09.28.(Да) -аас дарааллаар олгоно
Виз авах болон хилээр нэвтрэх	~ 2026.02.28	~ 2026.05.22	~ 2026.08.28	~ 2026.11.20

※ **Дээрх хуваарь дотоод нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөж болно.**

03 БүрдүүЛэх материал

Ангилал	БүрдүүЛэх материал	Тайлбар / Бичиг
Хувийн мэдээ -лэл	Элсэлтийн өргөдөл (1хувь)	Сургуулийн маягт
	Цээж зураг (1ш)	Паспортны зураг 3×4см
	Гэр бүлийн харилцааг батлах бичиг баримт (хуулбар)	Хятад бол төрөл садангийн гэрчилгээ байж болно
	Иргэний Үнэмлэхний хуулбар	Гадаад паспорт болон тухайн улсын иргэний Үнэмлэх
Боловсрол	Ахлах сургуулийн гэрчилгээ (хуулбар)	Апостиль эсвэл Элчингийн баталгаажуулалт заавал байх
	Ахлах сургуулийн дүнгийн хуудас (1 хувь)	
	Их сургуулийн гэрчилгээ /тодорхойлолт (хуулбар)	Хамааралтай хүмүүс
ЭрүүЛ мэнд	ЭрүүЛ мэндийн тодорхойлолт	Сүрьеэгийн шинжилгээний хариу багтсан
Санхүү	Банкны Үлдэгдлийн тодорхойлолт (эх хувь)	9,000 ам.долларoос дээш
БүртгэЛийн газар	- Биеэр болон шуудангаар бүртгүүЛэх : (31499) 충청남도 아산시 배방읍 호서로 79번길 20 Хусо Их сургууль, Олон улсын хамтын ажиллагааны баг International Cooperation Team, Hoseo University, 20, Hoseo-ro79beon-gil, Baebang-eup, Asan-si, Chungcheongnam-do, Republic of Korea - Цахим шуудангаар бүртгүүЛэх: apply@hoseo.edu	
Бусад зүйлс	- Бичиг баримтыг PDF файлаар цахим шуудангаар илгээж болох боловч эцэст нь эх хувиар нь заавал ирүүЛэх ёстой. - Элсэгчийн бүртгэлийн мэдээллийг баталгаажуулахын тулд нэмэлт бичиг баримт шаардаж болно.. - Солонгос эсвэл Англи хэл дээр биш бичиг баримтыг заавал Англи хэл дээр орчуулан но тариатаар батлуулж, эх хувийн хамт ирүүЛэх ёстой.	

04 Сургалтын төлбөр болон бусад зардал

Сургалтын төлбөр : 2,600,000 вон (20 долоо хоног, сурах бичгийн төлбөр тусдаа) / Элсэлтийн хураамж : 100,000 вон

Бусад зардал : Даатгал, дотуур байрны төлбөр гэх мэт (Хилээр нэвтэрсний дараа төлөх боломжтой)

Төлбөр төлөх дансны мэдээлэл

Ангилал	Дансны дугаар	Тайлбар
Дотоод гуйвуулга	IBK 643-345678-01-045 (ХҮлээн авагч : Hoseo University)	Солонгос улс дотроос воноор (KRW) шилжҮҮлэх тохиолдолд
Гадаад гуйвуулга	① Bank Name : Industrial Bank of Korea, Hoseo Branch ② Bank Address: 20, Hoseo-ro79beon-gil, Baebang-eup, Asan-si, Chungcheongnam-do ③ Swift Code : IBKOKRSEXXX ④ Account No : 643-345678-56-00018 ⑤ Beneficiary's name : Hoseo University	Солонгосоос бусад улс орноос долларoор (USD) шилжҮҮлэх тохиолдолд

05 Бусад зҮйлс

БҮртгҮҮлэх арга зам

- БҮртгҮҮлэхдээ бичиг баримтын эх хувийг шуудангаар илгээх эсвэл PDF файлаар цахим шуудангаар (e-mail) илгээж болно. Цахим шуудангаар илгээсэн тохиолдолд эх хувийг хилээр нэвтрэх хҮртлээ заавал ирҮҮлэх ёстой. Хэрэв цахим шуудангаар илгээсэн PDF файл болон эх хувь хоорондоо зөрвөл элсэлтийн зөвшөөрлийг цуцалж болзошгҮйг анхаарна уу.

Шалгалтын хугацаа

- Бичиг баримтыг шалгаж хариу өгөхөд ойролцоогоор 1-2 долоо хоног зарцуулна. Бичиг баримт дутуу тохиолдолд нэмэлтээр шаардаж болох бөгөөд ямар нэгэн асуудалгҮй бол ярилцлагын цагийг мэдэгдэнэ.
- Ярилцлагын дараа 1 долоо хоногийн дотор хариуг мэдэгдэх бөгөөд тэнцсэн элсэгчдэд сургалтын төлбөрийн нэхэмжлэх (INVOICE) илгээнэ.
- Сургалтын төлбөр төлөгдсөнөөс хойш 2-3 хоногийн дотор элсэлтийн зөвшөөрлийн бичгийг цахим шуудангаар хҮлээн авах боломжтой.
- Дээрх заасан хугацаанд хариу ирэхгҮй бол холбоо барих дугаараар лавлана уу

Визийн мэдээлэл

- Элсэлтийн зөвшөөрлийн бичиг хҮлээн авсан оюутан өөрийн оршин суугаа газарт байрлах БНСУ-ын Дипломат төлөөлөгчийн газарт (Элчин сайдын яам эсвэл Ерөнхий консулын газар) Ерөнхий сургалтын (D-4-1) виз мэдҮҮлэх ёстой. Улс орноос хамааран бҮрдҮҮлэх материал (Элсэлтийн зөвшөөрөл, Батлан даалтын бичиг, СанхҮҮгийн чадвар нотлох баримт г.м) өөр өөр байдаг тул урьдчилан шалгахыг хҮсэж байна.
- Виза олгох хугацаа улс бҮрт харилцан адилгҮй боловч 1 сараас дээш хугацаа зарцуулагддаг тул хичээлийн шинэ жил эхлэхээс хамгийн багадаа 2 сарын өмнө бичиг баримтаа бҮрдҮҮлж эхлэхийг зөвлөж байна. D-4-1 визний хҮчинтэй хугацаа ихэвчлэн 6 сар байдаг бөгөөд Солонгост ирсний дараа Хилээр нэвтрэх, гарах зохицуулах газарт (Immigration Office) хугацаагаа сунгах зааварчилгааг өгөх болно.

Ирэх Үеийн заавар (Нисэх онгоцны буудлаас тосох)

- Тэнцсэн хүмүүст Инчон нисэх онгоцны буудлын T1, T2 терминалаас тосох (Pick up) хуваарь болон тийзийн мэдээллээ оруулах URL хаягийг **и-мэйлээр** мэдэгдэх болно. Мэдээллээ сайтар шалгаж, нислэгийн тийзээ захиалахдаа анхаарна уу. Нисэх онгоцны буудлаас тосох Үйлчилгээ нь ихэвчлэн хичээл эхлэхээс **1 долоо хоногийн өмнө** явагддаг.
- Хувийн журмаар ирэх оюутнууд ч мөн адил ирэх хугацаа болон зорчих төлөвлөгөөгөө заавал урьдчилан мэдэгдэх ёстой.
- Товлосон хугацаанаас өөр цагт ирэх оюутнуудын хувьд хүний тооноос хамааран тосох боломжтой байж болох тул лавлаж асууна уу.

Хилээр нэвтэрсний дараа хийх зүйлс

- Хилээр нэвтэрсэн оюутнууд заавал Олон улсын хамтын ажиллагааны хэлтэс (Кан Сог Кю сургалтын байр 101 тоот)-т очиж уулзана уу.
- Солонгос хэлний сургалтын төвийн хичээлийн хуваарь, анги хуваарилалт, гадаад иргэний Үнэмлэх мэдүүлэх, банкны данс нээх, дотуур байр зэрэг мэдээллийг өгөх болно.
- Олон улсын хамтын ажиллагааны хэлтэст очихдоо гадаад паспорт, цээж зураг, оршин суух газрын түрээсийн гэрээ зэргийг биедээ авч очно уу.
- Харилцаа холбоог сайжруулах болон зар мэдээллийг цаг алдалгүй шалгахын тулд KakaoTalk эсвэл WeChat зэрэг сошиал сүлжээнд бүртгүүлэхийг зөвлөж байна.

Дотуур байрны мэдээлэл

- Оюутнуудын тав тухтай, аюулгүй суралцах орчныг бүрдүүлэхийн тулд хямд зардлаар дотуур байранд орох боломжтой. Дотуур байранд амьдарснаар олон орны оюутнуудтай харилцаж, соёл болон нийгэмших чадвараа хөгжүүлэх боломжтой юм
- Тэнцсэн хариугаа авсны дараа дотуур байранд амьдрах хүсэлтэй оюутнууд заавал өөрийн саналыг мэдэгдэнэ үү.
- Дотуур байрны төлбөр

Төрөл	Зардал		Тайлбар
4хүний өрөө	1,020,000вон		- - Их сургуулийн 1 улирал (15 долоо хоног)-ын төлбөр болно. - Солонгос хэлний сургалтын төв нь 20 долоо хоногийн хичээлтэй тул илүү гарсан хугацааны төлбөрийг тусад нь төлнө. - - Өглөө, оройн хоолоор хангана. **Баасан гарагийн оройн хоол болон амралтын өдрүүдэд хоол байхгүй** - Дотуур байрны дүрэм журмыг дагаж мөрдөх ёстой **В төрөл: 4 хүний өрөөнд 2 хүн амьдарна.**
2хүний өрөө	А төрөл	1,621,000вон	
	В төрөл	1,379,000вон	

Даатгалын зааварчилгаа

- Солонгос хэлний бэлтгэл ангийн бүх оюутнууд хилээр нэвтэрсний дараа сургуулиас зааварласан даатгалд багаараа хамрагдана. Даатгалын төлбөр нь ойролцоогоор 70,000~110,000 вон (1 жилийн хугацаатай, оюутны наснаас хамаарч өөр байна).
- Хилээр нэвтэрсэн өдрөөс хойш 6 сарын дараа Солонгос улсын иргэдийн адил Үндэсний эрүүл мэндийн даатгалд автоматаар хамрагдана. Даатгалын төлбөр нь ойролцоогоор 70,000~80,000 вон (1 сарын хугацаатай, оюутны наснаас хамаарч өөр байна).

Бүртгэл цуцлах

- Хичээл эхлэхээс өмнө бүртгэлээ цуцлах эсвэл виз татгалзсан зэрэг шалтгаанаар хилээр нэвтрэх боломжгүй болсон тохиолдолд бүртгэлийн хураамж (100,000 вон)-оос бусад сургалтын төлбөрийг бүрэн буцаан олгоно.
- Хилээр нэвтэрч хичээл эхэлсний дараа сургуулиас гарах тохиолдолд Солонгос хэлний сургалтын төвийн төлбөр буцаан олгох журмын дагуу буцаан олгоно.
  - Хичээлийн хугацааны 1/3-ээс өмнө: Сургалтын төлбөрийн 2/3-той тэнцэх хэмжээг
  - Хичээлийн хугацааны 1/3-ээс 1/2 хүртэл: Сургалтын төлбөрийн 1/2-той тэнцэх хэмжээг
  - Хичээлийн хугацааны 1/2-оос хойш: Буцаан олгохгүй.
- Бүртгэл цуцлах тохиолдолд холбоо барих хаягаар хүсэлтээ ирүүлнэ үү.

Холбоо барих мэдээлэл

SNS
kakao

e-mail : apply@hoseo.edu
Tel : +82-41-540-9712~15